

БАТЛАВ:
"БИДИСЕК" ХК

Б.ЛХАГВАДОРЖ
ТУЗ-ИЙН ДАРГА

2014 оны 05 сарын 30 -ны өдөр

“БидиСЕК” ХК- ИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “БидиСЕК” ХК-с Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн санд хүргүүлэх мэдээллүүд, харилцагч хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.2.1. “Мэдээллийн сан” гэж зохицуулалттай этгээдээс тус Хорооны зохицуулалттай этгээдийн мэдээллийн санд энэ журмаар тогтоосон хугацаанд ирүүлсэн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж болон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллүүдийг;

1.2.2. “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сан хариуцсан ажилтан” гэж БидиСЕК ХК-ийн мэдээллийн албаны ажилтанг ойлгоно. Гүйцэтгэх захирлын томилсон мэдээллийн ажилтан нь компанийн мэдээллийн сангийн мэдээлэл, нийтэд тогтмол хүргэх мэдээллүүдийг хариуцна. Дотоод хяналтын ажилтан мэдээллийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд ТУЗ, эрх бүхий албан тушаалтнуудад тайлагнана.

1.2.3. Мэдээллийг нээлттэй болгох” гэж үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгсэлээр дамжуулан хүргэхийг

1.2.4. “Тухай бүр мэдээлэх” гэж үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Хорооноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан хүргэхийг

1.2.5. Тодорхой үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дотоод мэдээлэл гэнэ.

24

1.2.6. “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д болон “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай” журамд заасан этгээдийг

1.2.7. “Давхар бүртгэл” гэж гадаад улсын хөрөнгийн биржид үндсэн бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Монгол Улсын үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэж арилжахыг

1.2.8. “Хугацаат тайлан” гэж үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэл хүргэх

2.1. Брокер, дилер анддерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөх “БиДиСЕК” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны Мэдээллийн сангийн журмын гуравдугаар хавсралт “МС-3-1” – ээс “МС-3-7” хүртэлх маягтын дагуу мэдээллийн санд хүргүүлэх мэдээллийг тухайн улирлын дараа сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.2. Мэдээллийн сан хариуцсан мэдээллийн ажилтан нь хуваарийн дагуу мэдээллийг Хорооны мэдээллийн санд хүргүүлэхээс гадна холбогдох мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 өдөрт багтааж тухай бүр шинэчлэн хүргүүлнэ.

2.3. Мэдээллийн сангийн мэдээллийг үнэн зөв, шуурхай бүрдүүлж ажиллахад албаны менежерүүд мэдээллийн ажилтанд дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3. БиДиСЕК ХК нь энэхүү журамд заасан мэдээллийг үнэн зөвөөр, тогтоосон хугацаанд батлагдсан маягтын дагуу гаргаж бичгэн болон цахим [/moh@frc.mn/](mailto:moh@frc.mn) хэлбэрээр Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

Гурав. Харилцагч хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх

3.1. ҮЦК нь харилцагчдад үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай дараах мэдээллээр хангах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан үнэт цаасны сүүлийн 6 сарын арилжааны идэвхи, үнэ ханш, арилжаатай холбоотой нийтэд мэдээлэхийг хуулиар хориглоогүй бусад мэдээлэл.

3.1.2. Үнэт цаас гаргагчийн хаяг, ерөнхий болон санхүүгийн байдлын талаарх мэдээлэл /Үүнд тухайн үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээлэхээр заасан санхүүгийн мэдээллүүд хамаарна/;

- 3.1.3. Үнэт цаасны арилжаанд оролцохтой холбоотой данс нээлгэх, захиалга өгөх заавар, гарын авлага;
- 3.2. Харилцагчтай гэрээ байгуулахын өмнө Брокер нь үнэт цаасны зах зээлийн талаарх ерөнхий ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг танилцуулна.
- 3.2.1. Үнэт цаасны арилжааны захиалга, хэлцэл хийгдэх явц, электрон арилжааны системийн талаар,
- 3.2.2. Үнэт цаас худалдах, худалдан авахад хүлээж болох зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл,
- 3.2.3. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын арав хоногийн дотор Хороонд мэдэгдэх зэрэг хуулийн дагуу үүсэх үүрэг хариуцлагууд.
- 3.3. Брокер нь харилцагчийн өгсөн захиалга биелэгдсэн тохиолдолд үнэт цаасны нэр, үсгэн код, хэлцэл хийгдсэн огноо, үнэ, тоо ширхэг, шимтгэлийн талаарх мэдээллийг гэрээнд заасан цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр нэн даруй мэдэгдэнэ.
- 3.4. ҮЦК нь харилцагч шаардсан тохиолдолд харилцагчийн дансны хуулгыг цахим шуудангаар явуулах буюу эсхүл харилцагч нууц үгийн тусламжтай онлайнгаар өөрийн дансыг шууд хянах боломжоор хангана.
- 3.5. ҮЦК нь харилцагчийн шаардсанаар өөрийн компанийн талаар дараах баримт мэдээллээр хангах үүрэгтэй. Үүнд:
- 3.5.1. Тухайн компанийн үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон бичиг баримт;
- 3.5.2. Компанийн санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;
- 3.5.3. Гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан, мэргэжилтнүүд нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн эсэх тухай мэдээлэл.
- 3.6. ҮЦК нь өөрийн цахим хуудас болон харилцагчдын мэдээлэл авахаар бүртгүүлсэн цахим шуудангаар дараах мэдээллийг тогтмол хүргэж ажиллана. Үүнд:

- 3.6.1. Хувьцааны тухайн өдрийн ханш;
- 3.6.2. МХБ-ийн арилжааны мэдээ;
- 3.6.3. Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ мэдээлэл;
- 3.6.4. Хувьцаат компанийн талаарх мэдээлэл;
- 3.6.5. Холбогдох хууль журам;
- 3.6.6. Шинээр гарч буй үнэт цаасны мэдээлэл;

Дөрөв. Нийтэд мэдээллийг тогтмол хүргэх

4.1 Хугацаат тайланг нийтэд мэдээлэх

- 4.1.1 БиДиСЕК ХК – ийн хугацаат тайланд хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан хамаарах бөгөөд Хорооны “ Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам” – ийн хавсралт ” Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тайланг гаргах” загварын дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 4.1.2 Хугацаат тайлангийн мэдээллийг бүрдүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг компанийн мэдээллийн ажилтан хариуцан ажиллах бөгөөд мэдээллийг үнэн зөв, цаг хугацаандаа олон нийтэд хүргэж ажиллахад компанийн менежерүүд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.1.3 БиДиСЕК ХК нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ.
- 4.1.4 Үнэт цаас гаргагчийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1 – ний өдрийн дотор өөрийн компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 4.1.5 Хэрэв компанийн хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нийтэд мэдээлэхээс өмнө компанийн ашиг, алдагдалын хэмжээ нийтэд тархаж энэ нь компанийн гаргасан үнэт цаасны үнэ ханшийг 15 хувь өөрчлөгдөхөд хүргэсэн бол компани тухайн тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн талаар нэн даруй нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.

4.2. Тухай бүр нээлттэй мэдээлэх мэдээлэл

4.2.1 “БиДиСЕК” ХК нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг тухай бүрт компанийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

- 4.2.2 Компаниас тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурьдсан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба эдгээрийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсоноос хойш ажлын 2 өдөрт багтаан өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаа дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 4.2.3. Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
- 4.2.4. Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдхүүн зах зээлд танилцуулах;
- 4.2.5. Үндсэн болон шинэ бүтээгдхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 4.2.6 Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 4.2.6. Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах тухай мэдээлэл;
- 4.2.7. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.2.8. Нийт ажиллагсадын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох
- 4.2.9. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;
- 4.2.10. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 4.2.11. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
- 4.2.12. Компани нь хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 4.2.13. Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх болон хязгаарлах;
- 4.2.14. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэл;
- 4.2.15. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь

хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;

- 4.2.16. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
 - 4.2.17. Компанийн ТУЗ-ийн бүрэлдхүүн өөрчлөгдөх;
 - 4.2.18. Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр;
 - 4.2.19. Хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч үнэт цаас гаргагчийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
 - 4.2.20. Компанийг өөрчлөн байгуулах шийдвэр;
 - 4.2.21. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр;
 - 4.2.22. Компани өр төлбөрөө эргэн төлөх санхүүгийн чадваргүй болох;
 - 4.2.23. Компанийн охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;
 - 4.2.24. Компанийг татан буулгах шийдвэр;
 - 4.2.25. Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, болон бусад эрх бүхий албан тушаалтнууд холбогдох болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой гэмт үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
 - 4.2.26. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр;
 - 4.2.27. Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
 - 4.2.28. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл;
- 4.3. Компани нь 4.2. дох заалтад заасан мэдээллийг нээлттэй болгохдоо Хороо, хөрөнгийн биржид тухайн асуудлаар гарсан албан ёсны шийдвэрийг ажлын нэ өдөрт багтаан хүргүүлнэ.
 - 4.4. 4.2 дох заалтад заасан мэдээллийг нийтэд мэдээллэх, хөрөнгийн биржийн цахим хуудсанд тавих этгээд нь гүйцэтгэх захирлын томилсон мэдээллийн ажилтан байх бөгөөд тухайн ажилтан болон гүйцэтгэх захирал компанийн тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
 - 4.5. Компанийн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан тохиолдолд дараах арга хэмжээг авна:
 - 4.6. Энэ журмын 4.2.-т заасан өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр гарч буй мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар судалж, холбогдох үндэслэл бүхий тайлбарыг хөрөнгийн биржид хуанлийн 3 өдөрт мэдэгдэнэ.
 - 4.7. Компанийн удирдлага тухайн огцом өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлнө гэж үзвэл энэ талаар олон нийтэд ажлын 1 өдөрт багтаан мэдээлнэ.

- 4.8. Хэрэв компанийн охин болон хараат компанийн үйл ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлт нь компанийн ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар нийтэд хуанлийн 2 хоногт мэдээлэх үүрэгтэй.

Тав. Нийтэд мэдээлсэн мэдээллийн архивыг бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа

5.1. Мэдээллийн үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд нэгэн зэрэгн хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар тогтоосон хугацаанд мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл 5 жилийн хугацаанд байршина.

5.2. Ниймэд мэдээлсэн мэдээллийг архивлан хавтаслаж 5 жилээр үзэж болхоор байна.

Зургаа. Мэдээллийг нээлттэй болгоход тавигдах

хязгаарлалт, хориглох зүйл

6.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу мэдээллийг нээлттэй болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцлийг бүрдүүлэхийг хориглоно.

6.2. Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.